

**“Бэрх Уул” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019.10.18-ний өдрийн
ээлжит бус хурлын тэмдэглэл**

2019.10.18

Улаанбаатар хот

“Бэрх Уул” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2019 оны 10 сарын 18-ний өдрийн 10 цаг 00 минутанд Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, UB INN зочид буудлын 4 давхарт хурлын танхимд эхлэв.

Хуралд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Гүйцэтгэх захирал А.Даваажав, тооллогын комиссын дарга болон гишүүнээр Э.Солонго, Ч.Сарнай итгэмжлэлээр 4 хувьцаа эзэмшигч, биечлэн 3 хувьцаа эзэмшигч нийтдээ 7 хувьцаа эзэмшигч хуралд оролцов.

Тооллогын комиссын дарга Э.Солонго: “Бэрх Уул” ХК-ийн 2019 оны 10 сарын 18-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирцийг та бүхэнд танилцуулья. Нийт 19,062,080 хувьцаанаас нийтдээ 99.66% буюу 18,998,405 ширхэг хувьцаа эзэмшиж буй 7 хувьцаа эзэмшигчид итгэмжлэгдсэн төлөөлөгч болон өөрийн биеээр оролцож хурлын ирц бүрдэж байгааг мэдэгдэж байна.

Хурлын дарга: “Бэрх Уул” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын хэлэлцэх асуудлын дагуу компанийн одоо ажиллаж байгаа ТУЗ-ийн гишүүд болон нэр дэвшиж буй ТУЗ-ийн гишүүдийн танилцуулгыг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Э.Солонго: Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналын хуудсаар санал хураалтын дүнг танилцуулав.

Компанийн шинэ ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдээс А.Даваажав 16.67%, Б.Мянганбаяр 16.67%, Жеймс Пассин 16.67%, Б.Наранзаяа 16.67%, Р.Бадрх 16.67%, Б.Баярцэнгэл 16.67%-ийн санал авч ердийн гишүүдэд сонгогдлоо.

Хараат бус гишүүдэд Л.Тэмүүжин 33.33%, Ё.Амарбат 33.33%, Д.Энхболд 33.33%-ийн саналтайгаар сонгогдлоо.

Хурал 11:00 өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хянасан

хурлын дарга:

...../А.Даваажав/

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

...../Х.Шүрэнгэрэл/